



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Татварын ногдлыг жишиг үнийн аргаар
тодорхойлох журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 353 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд холбогдох заавар, аргачлалыг батлуулж мөрдүүлэхийг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ТАТВАРЫН НОГДЛЫГ ЖИШИГ ҮНИЙН АРГААР ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлд заасан “Татварын ногдлыг тодорхойлох боломжгүй байх” тохиолдолд татварын алба татвар төлөгчийн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлж, татварын хяналт шалгалт хийх, үйл ажиллагааг зохион байгуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Татварын алба өөрт байгаа болон гуравдагч этгээдийн мэдээлэлд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д заасан жишиг үнийн аргаар татварын ногдлыг тодорхойлоход энэхүү журмыг баримтална.

1.3.Татварын хяналт шалгалтын явцад татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлохдоо шаардлагатай тохиолдолд “Байр агуулахад нэвтрэн орж, мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх журам”-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

1.4.Татварын хяналт шалгалтын явцад татварын алба, татварын улсын байцаагчийн үйл ажиллагаанд эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн баталсан Татварын албаны хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг мөрдөж болно.

1.5.Татварын ногдлыг жишгээр тодорхойлох үеийн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, холбогдох баримтыг Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгэнэ.

Хоёр.Жишиг үнийн арга хэрэглэх нөхцөл

2.1.Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасны дагуу татварын алба дараах үндэслэлээр татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий этгээдийн мэдээлэл, эсхүл өөрт байгаа мэдээлэлд үндэслэн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлно:

2.1.1. Татвар төлөгч хуульд заасны дагуу анхан шатны баримт бүрдүүлээгүй;

2.1.2. Татвар төлөгч нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, бүртгэлийг дутуу буюу буруу хөтөлсөн;

2.1.3. Татвар төлөгчийн тайлан, бүртгэл алдагдсан буюу устсан;

2.1.4. Татвар төлөгчийн татварын тайлангийн үзүүлэлт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад татварын ногдол дутуу тодорхойлогдсон нь илт байгаа;

2.1.5. Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд холбогдоогүй.

Гурав.Татварын ногдлыг тодорхойлоход ашиглах мэдээллийн эх үүсвэр

3.1.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлохдоо ойролцоо нутаг дэвсгэрт ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг, харьцуулалт хийх боломжтой татвар төлөгч олон байгаа тохиолдолд хэд хэдэн татвар төлөгчтэй харьцуулалт хийн татварын ногдлыг тодорхойлж болно.

3.2.Тусгай мэргэжил шаардсан ажил үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгчийн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох боломжгүй тохиолдолд тухайн салбараар мэргэшсэн мэргэжилтэн /цаашид “шинжээч” гэх/ ажиллуулж дүгнэлт гаргуулан, татварын ногдлыг тодорхойлохдоо уг дүгнэлтийг ашиглаж болно.

3.3.Шинжээч ажиллуулсны ажлын хөлсийг хяналт шалгалтад хамрагдаж буй татвар төлөгч төлнө.

3.4.Тухайн татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал нөхцөл бүхий, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгч байхгүй тохиолдолд тухайн зах зээлийн үнийн мэдээлэл, статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан ёсны үнийн мэдээллийг ашиглан татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлно.

3.5.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлоход дараах эх үүсвэрийн үнийн мэдээллийг ашиглана:

3.5.1. мал аж ахуйн анхдагч түүхий эдийн үнийг Монголын үндэсний худалдаа аж, үйлдвэрийн танхимийн албан ёсны цахим хуудас [/www.mongolchamber.mn/](http://www.mongolchamber.mn/), Хөдөө аж ахуйн биржийн цахим хуудас [/www.mce.mn/](http://www.mce.mn/) болон статистикийн үнийн мэдээлэл;

3.5.2. уул уурхайн бүтээгдэхүүний үнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын газрын цахим хуудас [/www.mgram.gov.mn/](http://www.mgram.gov.mn/) болон статистикийн үнийн мэдээлэл

3.5.3. барилгын материалын үнийг статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үнийн мэдээлэл;

3.5.4. зээлийн хүүг Монгол банкны цахим хуудас [/www.mongolbank.mn/](http://www.mongolbank.mn/) -д мэдээлсэн арилжааны банкны зээлийн хүүгийн мэдээлэл;

3.5.5. санхүүгийн түрээсийн хүүг адил төрлийн бүтээгдэхүүнийг санхүүгийн түрээсийн нөхцлөөр борлуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн зарласан хүүгийн мэдээлэл;

3.5.6. шатахуун болон шатах, тослох материалын үнийг гаалийн байгууллагын тухайн үед ашигласан үнэ болон статистикийн байгууллагын үнийн мэдээлэл;

3.5.7. спиртийн үнийг онцгой албан татвар ногдуулалтын мэдээлэл болон зах зээлийн үнийн мэдээлэл;

3.5.8. хүнсний бараа, гэр ахуйн бараа, холбогдох бусад барааны үнийн мэдээллийг үнийг статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үнийн мэдээлэл, гаалийн мэдээлэл болон зах зээлийн үнийн мэдээлэл;

3.6.Татварын ногдлыг тодорхойлох жишиг үнэд дээр дурдсан үнийн мэдээллээс гадна холбогдох байгууллагуудын зарласан үнэ болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласан үнэ, зар сурталчилгааны үнэ, зах зээлийн үнийн холбогдох эх үүсвэрийн мэдээллийг ашиглаж болно.

3.7.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлоход ашиглах үнийн мэдээллийн эх үүсвэрийг татварын албаны албан ёсны цахим хуудас [/www.mta.mn/](http://www.mta.mn/)-д зарлана.

Дөрөв.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох

4.1.Татвар төлөгч хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, дутуу буюу буруу хөтөлсөн, татварын тайлан үйлдэж тушаагаагүй, тайлан үйлдэж тушаасан боловч холбогдох баримт бичгийг татварын хяналт шалгалтын явцад гаргаж өгөөгүй, баримт бичгийг гаргаж өгсөн ч үнийн мэдээлэл бодит байдалд

нийцээгүй тохиолдолд татварын алба энэ журмын 3-т заасан эх үүсвэрийн мэдээлэлд үндэслэн жишиг үнийн аргаар төлөх татварын хэмжээг тодорхойлно.

4.2. Татварын алба энэ журамд заасан үндэслэлээр татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлохдоо шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг томилж болно.

4.3. Татвар төлөгчийн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох явцад өөр нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нь нотлогдсон тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн татварын албаны даргад хүсэлт хүргүүлэн, тухайн татварын албатай хамтран ажиллаж болно.

4.4. Татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал нөхцөл бүхий, адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчийн үйл ажиллагаа болон тухайн зах зээлийн үнийн эх үүсвэрийн мэдээлэлтэй уялдуулан харьцуулах байдлаар жишиг үнийг тодорхойлохдоо дараах нөхцөлийг харгалзана:

4.4.1. эдийн засгийн салбарын ангилал, эрхлэх үйл ажиллагааны төрөл;

4.4.2. хөрөнгийн хэмжээ, санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцаа;

4.4.3. газар зүйн байрлал, бүсчлэл, эрхлэх үйл ажиллагааны зах зээлийн цар хүрээ, технологийн ижил төстэй байдал, борлуулалтын суваг;

4.4.4. албан хаагчдын тоо, бүтэц, цалингийн мэдээлэл, нийгмийн даатгалд хамрагдалтын мэдээлэл;

4.4.5. ижил тайлант хугацааны нөхцөл, улс төр, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн ижил төстэй цаг хугацааны нөхцөл.

4.5. Энэ журмын 4-т заасан нөхцөлийг харгалзан үзэж татварын алба харьцуулалтыг дараах байдлаар хийнэ:

4.5.1. харьцуулалт хийх хүчин зүйлийг тодорхойлох;

4.5.2. харьцуулалт хийх талыг сонгох;

4.5.3. харьцуулалт хийх талуудын харьцуулах байдлын хүчин зүйлсийг харьцуулж, зөрүүг тогтоох;

4.5.4. харьцуулалт хийхэд тусгайлан авч үзэх ажил гүйлгээг тодорхойлох;

4.5.5. харьцуулалтын тохируулга хийж, татварын ногдлыг тодорхойлох.

4.6. Энэ журмын 4.3-т заасны дагуу харьцуулалт хийхдээ дараах аргыг ашиглан жишиг үнийг тодорхойлж болно:

4.3.1. нэг төрлийн ажил гүйлгээг харьцуулах; /тодорхой бүтээгдэхүүнийг борлуулсан үнэ, борлуулалтын нөхцөл гэх мэт/

4.3.2. багц ажил гүйлгээг харьцуулах;

4.3.3. үр дүнг нийт ашгийн түвшингээр харьцуулах;

4.3.4. үр дүнг цэвэр ашгийн түвшингээр харьцуулах;

4.3.5. үр дүнг хөрөнгийн өгөөж болон бусад үзүүлэлтээр харьцуулах;

4.3.6. бусад.

4.5. Татварын алба жишиг үнийг тодорхойлохдоо холбогдох журамд заасан харилцан хамаарал бүхий этгээдийн хоорондын гүйлгээнд ашигладаг үнэ шилжилтийн тохируулга хийх аргуудаас аль тохиромжтой аргыг сонгон хэрэглэж болно.

4.6. Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлж буй татварын алба, татварын улсын байцаагч нь хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тэмдэглэл үйлдэн, тайлант он тус бүрээр татварын ногдлыг жишгээр тодорхойлж, Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журамд заасны дагуу хяналт шалгалтын шийдвэрийг хавсралт баримт бичгийн хамт үйлдэнэ.